



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 1/02

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээ хийх журам"-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын 8 дугаар багийн иргэн Ганболдын Ууганбаярын иж бүрэн гэр, тавилга, эд зүйлс шатсан тул нөхцөл байдлын үнэлгээ тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батчулуун (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ц.Гомбосүрэн (8 дугаар багийн Засаг дарга)

Ж.Солонго (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Э.Очир-Эрдэнэ (Архитектор)

Н.Отгонбаяр (Нярав)

2. Үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан үнэлж, тайланг харьяалах онцгой байдлын байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсэг (Д.Батчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ